



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/519

Арвайхээр сум

Гарьд цолны мялаалга наадам зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн харьяат Монгол улсын Гарьд Цэдэнсодномын Бямба-Отгонд хүндэтгэл үзүүлэх “Гарьд” цолны мялаалга наадмыг 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсугай.

2.Мялаалга наадам зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулах салбар ажлын хэсгүүдийг батлан, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1026

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 12-ны өдрийн 41/СЗД дугаар
захирамжийн хавсралт



**МЯЛААЛГА НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ө.Жамдүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга)

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Д.Өсөх-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын дарга)

М.Дэлгэрсайхан (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч, хурандаа)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Х.Лхагва (Төгрөг сумын Засаг дарга)

Ч.Доржбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга : Р.Ариунбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуй газрын мэргэжилтэн)

-оОо-